

### **Хөдөө аж ахуй, хөдөө орон нутгийн хөгжлийн төслийн явц**

Азийн хөгжлийн банк (АХБ) нь Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг (ГТХАН)-тэй хамтран Хөдөө аж ахуй, хөдөө орон нутгийн хөгжлийн төслийг (ХААХОНТ) бэлтгэхэд техникийн туслалцаа үзүүлж байна. ХААХОНТ нь хөдөө аж ахуйн арав орчим үйлдвэрлэгч/компаниудад тусалж тэдгээрийн бүтээгдэхүүнийг олон улсын “ниш” буюу өндөр чанар бүхий онцгой бүтээгдэхүүний зах зээлийн чанарын шаардлагыг хангахуйц хэмжээнд хүртэл сайжруулах бололцоогоор хангах юм. нь Үүний тулд уг төсөл нь компаниудын бэлтгэн нийлүүлэх болон бүтээгдэхүүн үйлдвэрлэх тогтолцоо, тэдгээрийн сүлжээг бэхжүүлэхэд анхаарч, түүнд чиглэсэн урт хугацааны хөнгөлөлттэй зээл олгох ба хөдөө орон нутгийн дэд бүтцийг сайжруулахад шаардлагатай улсын хөрөнгө оруулалтыг тодорхойлж, нутгийн иргэд ба иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангах юм. Үүний зэрэгцээ олон улсын түвшинд хэрэглэгчдэд хандан Монголын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний онцлог шинж чанар, буюу бусад орны хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээс ялгарахуйц Монголын “брэнд” сурталчлах ажлыг кампани хэлбэрээр өрнүүлнэ.

Өнөөдрийн байдлаар АХБ/ГТХАН-ийн хамтарсан баг Төсөл бэлтгэх техникийн туслалцааны хүрээнд дараах үйл ажиллагааг явуулаад байна:

- Үнэ цэнийн сүлжээний мэргэжилтэн Харалд Ландауэрын оролцоотой үнэ цэнийн сүлжээний концепцийн тухай хувийн хэвшлийнхэнд зориулсан 2 удаагийн семинар Улаанбаатар ба Дарханд зохион байгуулсан. (2006 оны 11-р сар)
- Хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн үнэ цэнийн сүлжээнд дүн шинжилгээг хийж, түүнд түшиглэн урьдчилсан байдлаар зарим зөвлөмжийг боловсруулсан (2006 оны 11-12-р сар)
- Уг төсөлд хамрагдах өргөдлөө ирүүлэх урилгыг аж ахуйн нэгжүүдэд дээрх 2 семинар болон өдөр тутмын сонингоор дамжуулан тараасан. (2006 оны 11-12-р сар)
- 240 өргөдлийн маягтыг сонирхсон иргэд, аж ахуйн нэгжүүдэд тарааж, 147 бөглөсөн өргөдлийн маягтыг хүлээн авч, түүнээс шаардлага хангахуйц хэмжээнд бөглөсөн 74 маягтыг шигшиж авсан. (2006 оны 12-р сараас 2007 оны 1-р сар)
- 9 гишүүн бүхий Зөвлөх Хороог төрийн 4 төлөөлөгч (Санхүү, Эдийн Засгийн Яам, Үйлдвэр, Худалдааны Яам, Хүнс Хөдөө Аж Ахуйн Яам), судалгааны байгууллага/иргэний нийгмийн 2 төлөөлөгч (Хүний Эрх, Хөгжил Төв, Нийгмийн Хөгжлийн Төв), хувийн хэвшлийн 1 төлөөлөгч (Монголын Үйлдвэрлэл, Үйлчилгээний Хоршоодын Холбоо) болон хэрэгжүүлэгч байгууллагуудын 2 төлөөлөгч (АХБ, ГТХАН)-ийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. (2007 оны 1-р сар)
- Компаниудын богино жагсаалтыг бэлтгэх, шигших шалгууруудыг боловсруулсан бөгөөд сонгон шалгаруулалтын хоёрдахь үе шатанд шилжсэн компаниудын санхүүжилт хүсэх ерөнхий төслийн маягтын төслийг боловсруулсан. (2007 оны 1-р сар)
- ТББ-уудтай үүлзалт зохион байгуулж төслийн тухай болон хоёрдахь шатны сонголтын шалгуур үзүүлэлтүүдийг танилцуулан, ялангуяа нийгмийн хариуцлага бүхий хөрөнгө оруулалт ба байгаль орчны хувьд хоргүй үйл ажиллагаатай холбоотой шалгууруудын талаар тэдний саналыг авсан. (2007 оны 1-р сарын 25)
- Хөдөө орон нутгийг хөгжүүлэх, хөдөөгийн иргэдийг чадавхжуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 13 олон улсын байгууллага, олон улсын санхүүжилттэй төслүүдтэй уулзаж мэдээлэл, туршлага солилцсон. (2006 оны 1-р сар)

- Зөвлөх хорооны анхны уулзалт болж Зөвлөх хорооны бүрэлдэхүүн, ажлын чиг үүрэг, компаниудыг шигших шалгууруудын төслийг хэлэлцэж баталсан. (2007 оны 2-р сарын 1)

Зөвлөх хорооны хоёрдахь уулзалтыг 2007 оны 2-р сарын 9-нд зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд энэ уулзалтаар компаниудыг эрэмбэлсэн жагсаалттай танилцаж санхүүжилт хүсэх ерөнхий төсөл боловсруулах сонгон шалгаруулалтын хоёрдахь үе шатанд шилжих компаниудыг сонгоно. Мөн уулзалтаар хөрөнгө оруулалтын төслийг бүрэн хэмжээгээр боловсруулах гуравдахь үе шатанд шилжих компаниудыг сонгоход хэрэглэх шалгууруудыг хэлэлцэнэ. Компаниудыг сонгосны дараа олон улсын болон үндэсний зөвлөхүүдээс бүрдсэн баг дөрвөн сарын турш эдгээр компанитай нягт хамтран ажиллаж хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөө боловсруулахад нь туслана. Эцэст нь хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нь үндэслэн арав орчим компанийг сонгон шалгаруулж урт хугацааны хөнгөлөлттэй зээл олгоно.

Төслийн баг нь энэ бүх үйл явцын турш төслийн хэрэгжилтийн ил тод байдлыг бүрэн хангаж, судалгаа, шинжилгээний байгууллага, төрийн бус байгууллага, үндэсний болон орон нутгийн түвшний төрийн байгууллага, хувийн хэвшил зэрэг сонирхогч талуудын оролцоог ханган ажиллана. Тухайлбал, төслийн тухай мэдээллийг англи, монгол хэл дээр цаг тухайд нь хүргэх веб хуудас ажиллуулах ба сонирхогч этгээдүүдтэй зөвлөлдөх уулзалтыг тогтмол зохион байгуулна. Түүнчлэн, АХБ нь төслийн хүрээнд хамрагдах бүлгүүдийн ядуурлын түвшинг тогтоох үнэлгээ хийх ба төслийн хэрэгжилтийг үр дүнтэй болгох үүднээс нутгийн иргэдэд түшиглэсэн мониторингийн тогтолцоог бий болгоно. АХБ нь төслийг хэрэгжүүлэхдээ жендерын асуудлыг мөн анхаарах болно.

Дэлгэрэнгүй мэдээллийг дараахь материалаас үзнэ үү:

1. [Зөвлөх хорооны бүрэлдэхүүн](#)
2. [Төслийн багийн бүрэлдэхүүн](#)
3. [Компанийг сонгох шалгуур үзүүлэлтүүд](#)
4. [Төслийн 2 дахь шатанд сонгох шалгуур үзүүлэлтүүдийн төсөл](#)
5. [Үнэ цэнийн сүлжээнд хийсэн анализ болон сүлжээг сайжруулах тухай зөвлөмж](#)
6. [ТББ-уудтай зөвлөлдөх уулзалтад оролцогсод/уригдагсад](#)
7. [ТББ-уудтай хийсэн уулзалтаас гарсан саналууд](#)